



60

МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 467

Улаанбаатар хот

Химиин бодисын хордлогыг тандах  
мэдээлэх журам

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.19, Химиин хорт болон аюултай бодисын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

- Химиин бодисын хордлогыг тандах, мэдээлэх журмыг нэгдүгээр, Химиин бодисын хордлогын байнгын тандалтыг мэдээлэх маягтыг хоёрдугаар, Байнгын тандалт, тохиолдол, дэгдэлтийн үеийн мэдээлэл дамжуулах сүлжээг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Энэхүү журмыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал), Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Ө.Ганчимэг)-д тус тус даалгасугай.
- Химиин бодисын хордлогын бүртгэл мэдээллийг нэгтгэн жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд хүргүүлж байхыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт, мэдээг нэгтгэн, мэдээллийн сан бүрдүүлж тайланг жил бүрийн 2 дугаар сарын 1-ны дотор Эрүүл мэндийн яаманд ирүүлж, мэдээллийг эрүүл мэндийн статистик үзүүлэлтэд тусгаж байхыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Ө.Ганчимэг)-д даалгасугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуюа)-д үүрэг болгосугай.



002988

Эрүүл мэндийн сайдын  
2013 оны 12 сарын 10-ний өдрийн  
467 тоот тушаалын  
нэгдүгээр хавсралт

61

## Химиин бодисын хордлогыг тандах, мэдээлэх журам

### Нэг. Нийтлэг үндэслэл

- Химиин бодисын хордлого (ХБХ)-ыг тандах, бүртгэх, мэдээлэх, тогтолцоог сайжруулах, хордлогоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- Журмыг хэрэгжүүлэхэд холбогдох хууль тогтоомж, олон улсын конвенцуудыг мөрдлөг болгоно.
- ХБХ-ыг тандах, мэдээлэх, сэргийлэх үйл ажиллагаанд оролцогч нийслэл, аймаг, орон нутгийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын асуудал хариуцсан холбогдох бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд энэхүү журмыг мөрдөж ажиллана.
- ХБХ-ыг тандах, мэдээлэх үйл ажиллагаанд хордлогын тухай яаралтай болон тогтмол мэдээг хүлээн авах, бүртгэх, эрсдлийн үнэлгээ, дүн шинжилгээ хийх, тархвар судлалын оношийг баталгаажуулах, хордлогын эх үүсвэр, шалтгаан, хамрах хүрээ, тархалтын түвшинг тогтоох, эргэн мэдээлэх болон бусад хариу арга хэмжээ авах зэрэг үйл ажиллагаа хамаарна. Тандалт, судалгааны үр дүнг ХБХ-оос сэргийлэх, хянах талаар оновчтой арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлэхэд ашиглана.
- ХБХ-ын үед хордлогын шалтгаан тодорхойгүй, цаашид тархах, хүрээлэн буй орчин бохирдох, нэгэн зэрэг олон хүний эрүүл мэнд, амь нас эрсдэх, улс, орон нутгийн техник, мэргэжлийн чадавх, эдийн засгийн дотоод нөөцөөс давсан хохирол учруулах гамшгийн нөхцөл бүрдсэн бол "Гамшгаас хамгаалах тухай" хуулийн дагуу хариу арга хэмжээг зохион байгуулах бөгөөд гамшгийн тохиолдол энэхүү журамд хамаарахгүй болно.
- Энэ журамд дурдсан нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
  - "Химиин бодис" гэж химиин тогтмол найрлагатай бөгөөд өөрийн тодорхой шинж чанарыг агуулсан материин нэг хэлбэрийг;
  - "Аюултай химиин бодис" гэж тэсрэмтгий, шатамхай, исэлдүүлэгч, идэмхий шинж чанартай химиин бодисыг;
  - "Хортой химиин бодис" гэж хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор аюул учруулах шинж чанартай химиин бодисыг;
  - "Химиин бодисын хордлого" гэж химиин бодисын нөлөөгөөр хүний бие махбод эрхтэн тогтолцооны бүтэц, үйл ажиллагаанд эмгэг үүсэхийг;
  - "Химиин хордолтын голомт" гэж хортой, аюултай химиин бодисын бохирдолд өртсөн газар, нутаг дэвсгэрийг;

- 62
- 6.6 "Химиин хордолтын бүс" гэж хортой, аюултай бодисын тархалтаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд тодорхой хугацаанд сөрөг нелөө үүссэн хязгаарлалтын бүсийг;
- 6.7 "ХБХ-ын дэгдэлт" гэж нэг төрлийн химиин бодисын хордлогын хоёр ба түүнээс олон тохиолдол илрэхийг;
- 6.8 "Тандалт" гэж олныг хамруулсан үзлэг шинжилгээ, судалгаагаар тухайн өвчлөлийг илрүүлэх арга хэмжээг;
- 6.9 "Байнгын тандалт" гэж үйл ажиллагаа нь тасралтгүй үргэлжлэх тандалтыг;
- 6.10 "Тохиолдол-дэгдэлтийн үеийн тандалт" гэж ХБХ-ын тухайн тохиолдол, дэгдэлтийн үед хордлогын эх үүсвэр, шалтгаан, хамрах хүрээ, нелөөлөх хүчин зүйлс, дамжих замыг тодруулж, эрт сээрэмжлүүлэх, таслан зогсоох хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг;
- 6.11 "Мэдээлэх" гэж химиин бодисын хордлогын тухай мэдээллийг нэг буюу түүнээс олон тооны эх үүсвэрээс цуглуулж, мэдээллийн сан үүсгэх зорилго бүхий үйл ажиллагааг;
- 6.12 "Гамшиг" гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг;

### **Хоёр. Зохион байгуулалтын арга хэмжээ**

1. ХБХ-ын өвчлөл болон химиин бодисын импорт, хэрэглээ, устгалын тухай холбогдох мэдээллүүдийг нэгтгэх, мэдээлэх үйл ажиллагааг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (НЭМҮТ) үндэсний түвшинд хариуцан гүйцэтгэнэ.
2. "Химиин хорт болон аюултай бодисын хууль"-ийн 7.2-д заасны дагуу төрийн захиргааны төв болон холбогдох байгууллагуудын салбарын чиг үүрэгтэй уялдсан химиин хорт болон аюултай бодисын мэдээллийн нэгдсэн сангаас химиин бодисын бүртгэл, импорт, хэрэглээ, устгалын үйл ажиллагааны тухай мэдээллийг НЭМҮТ нэгтгэн авч, тандалтын үйл ажиллагаанд ашиглана.
3. ХБХ-ын тандалтын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар (ЭМГ) хариуцан гүйцэтгэж, Мэргэжлийн хяналт, мал эмнэлэг, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг цуглуулна.
4. ХБХ-оос урьдчилан сэргийлэх, тандах, мэдээлэх, хордлогын эсрэг эрт сээрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг НЭМҮТ хариуцан гүйцэтгэж, орон нутгийн холбогдох мэргэжлийн байгууллагуудад хэрэгжүүлнэ.
5. ХБХ-д хамаарах үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм"-ийн дагуу бүртгэж мэдээлнэ.
6. ХБХ-д хамаарах Хүнсний химиин хордлогыг "Хоол хүнсээр дамжих өвчнийг тандах, хянах журам"-ын дагуу бүртгэж мэдээлнэ.
7. ХБХ-ын тандалтыг байнгын болон тохиолдол дэгдэлтийн үеийн гэсэн 2 хэлбэрээр зохион байгуулна.

## **Гурав. Байнгын тандалт, мэдээллийн үйл ажиллагаа**

63

1. Байнгын тандалтыг уг журмын Хавсралт 3.А-д заасан байнгын тандалтын мэдээллийн сүлжээний дагуу хийж гүйцэтгэх бөгөөд энэ нь химиин бодисын эрсдлийн үнэлгээ хийж эрсдлийг эрт илрүүлэх, сээрэмжлүүлэх, хордлого гарах нөхцөл боломжийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангахад оршино.

2. Байнгын тандалтад хүн амын ХБХ-ын тархалтын байдал, хөдөө аж ахуй, мал эмнэлэг (амьтан, ургамлын гаралтай түүхий эд бэлтгэл, ферм, мал нядалгааны газар), химиин үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний байгууллагын эрүүл ахуйн нөхцөл, хүнсний бүтээгдэхүүний химиин бохирдолт, малын өвчлөлийн хяналт, лабораторийн шинжилгээ, баталгаажуулах судалгааны дүн зэрэг мэдээ, бүртгэл, тайланг цуглуулах, нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх, эрт сээрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах зэрэг үйл ажиллагаа хамаарна.

3. ХБХ-ын тохиолдлыг тус тушаалын 2.3-д заасны дагуу аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар (ЭМГ) гүйцэтгэх бөгөөд тандалт үнэлгээний жилийн тайланг нэгтгэн боловсруулж, Маягт №1-ийн /Хавсралт 2/ дагуу бүртгэн жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор НЭМҮТ-д электрон шуудан болон бичгээр мэдээлнэ.

4. НЭМҮТ нь нийслэл, орон нутгийн ЭМГ-аас ирүүлсэн ХБХ-ын тайланг нэгтгэн боловсруулж, Маягт №2-ийн /Хавсралт 2/ дагуу бүртгэн, нэгдсэн тайланг жил бүрийн 2 дугаар сарын 1-ны дотор Эрүүл мэндийн яаманд мэдээлнэ.

5. Тандалт, мэдээллийн дүнг үндэслэн холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд нь хүн амын дунд ХБХ-ын шалтгаан зүй, эрсдэлт хүчин зүйлс, эдийн засгийн үр дагавар (өвчтөний эмчилгээ, асаргаа сувилгаанд өрх, эмнэлгийн байгууллагаас гарах зардал, хөдөлмөрийн чадвар алдалтын зардал г.м), хортой, аюултай химиин бодисын хор аюул, хүнс ба орчны бохирдолт зэрэг асуудлаар эрсдэлийн үнэлгээ, тусгай судалгааг 3-5 жил тутамд хийж тайланг ЭМЯ болон холбогдох байгууллагуудад хүлээлгэж өгнө.

6. ЭМЯ нь тандалт, судалгааны үр дүнг ХБХ-ыг хянах, сээрэмжлүүлэх хариу арга хэмжээ авах, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох, бодлого шийдвэр гаргахад ашиглана.

## **Дөрөв. Тохиолдол - дэгдэлтийн үеийн тандалт, мэдээллийн үйлажиллагаа**

1. Тохиолдол-дэгдэлтийн үеийн тандалт, мэдээллийг ХБХ-ын тухайн тохиолдол, дэгдэлтийн үед хордлогын эх үүсвэр, шалтгаан, хамрах хүрээ, нөлөөлөх хүчин зүйлс, дамжих замыг тодруулж, эрт сээрэмжлүүлэх, таслан зогсоох хариу арга хэмжээ авахад ашиглана.

2. Нийслэл, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд ХБХ-ын тохиолдлыг эрүүл мэнд, байгаль орчин, батлан хамгаалах, хяналт шалгалт, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад уг журмын Хавсралт 3.Б-д заасан тохиолдол-дэгдэлтийн үеийн мэдээллийн сүлжээний дагуу мэдээлнэ.

3. ХБХ-ын тохиолдлыг анх оношилсон эрүүл мэндийн байгууллагын ажилтан нь аймаг, нийслэлийн НЭМГ, ОБГ, цагдаагийн байгууллагад холбооны хэрэгслийг ашиглан (утас, факс, электрон шуудан) яаралтай мэдээлнэ.

4. ХБХ-ыг анх оношилсон эмч голомтод хордлого тайлах анхны арга хэмжээг авч, тархвар судлалын анхан шатны судалгаа хийнэ.

5. Аймаг, нийслэлийн ЭМГ-ын эрүүл мэндийн мэдээллийн мэргэжилтэн буюу статистикч эмч тохиолдол бүрийг бүртгэж, тухайн байгууллагын дарга, тархвар судлагч, лабораторийн эмчид яаралтай мэдээлнэ.

6. Тархвар судлагч эмч тандалтын анхан шатны нэгжээс ирүүлсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хордлогын тохиолдлын тоо, босго үзүүлэлтэд хүрсэн (нэг голомтонд 2 ба түүнээс дээш тохиолдол гарсан, аюултай химийн бодисын хордлого илэрсэн, хүн нас барсан) тохиолдолд химийн бодисын хордлогын үед дагаж мөрдөх тандалтын стандарт, тушаал, заавар, журмын дагуу хариу арга хэмжээг зохион байгуулна.

7. ХБХ-ын тохиолдол дэгдэлтийн үед аймаг, нийслэлийн ЭМГ бусад холбогдох байгууллагуудтай хамтран хордлогын голомтод тархвар судлалын тандалт, судалгаа, хяналтыг зохион байгуулж, эрүүл зүйн ба эмнэл зүйн хамтарсан дүгнэлт гаргана. Хордлогын тохиолдлыг мал амьтны гаралтай өвчин, пестицид, малын эмийн буруу хэрэглээ, тариалалтын явц, хүнсний үйлдвэрлэл, түгээлт, импортын хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой гэж үзсэн тохиолдолд хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуй, хилийн хяналтын албадуудад мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулна.

8. Тухайн тохиолдол – дэгдэлтийн үеийн тандалтын үйл ажиллагаа хордолтын бус нутгийн холбогдох байгууллагуудын хүчин чадлаас хэтэрсэн тохиолдолд Монгол улсын эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага эрүүл ахуй, халдварт хамгааллын улсын байцаагч, тархвар судлагч, халдварт судлаач эмч, лабораторийн мэргэжилтэн, орчны болон эмнэл зүйн хор судлаачийн бүрэлдэхүүнтэй мэргэжлийн багийг томилон ажиллуулна. Шаардлагатай тохиолдолд орон нутгийн засаг дарга, малын эмч, ургамал хорио цээрийн мэргэжилтэн, хүнсний шинжээч, хор судлаач, вирус судлаач, хүнсний үйлдвэрлэлийн төлөөлөгч зэрэг холбогдох мэргэжилтнүүдийг татан оролцуулж болно.

9. Мэргэжлийн баг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан аргачлалын дагуу 5 үе шаттай дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

9.1. Талбарын ажилд бэлтгэх: Шаардлагатай шинжилгээний дээжийг цуглуулж, асуумж судалгаа авч, үүссэн нөхцөл байдалтай ижил тохиолдлуудын талаарх судалгааны материал, хэвлэлийн тойм болон бусад шаардлагатай мэдээллийн дагуу бэлтгэл ажлыг хангана.

9.2. ХБХ гарсан эсэхийг тодорхойлох: Үүссэн нөхцөл байдалд харгалзах тохиолдлын тоо нь хэвийн үед илэрдэг тохиолдлын тооноос олон эсэхийг тодорхойлж, ХБХ-д нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс, шалтгааныг тогтооно.

9.3. ХБХ-ын оношийг баталгаажуулах: Химийн бодисын хурц болон архаг хордлогын шалтгааныг эмнэлзүйн шинж тэмдэг, эмчийн үзлэг,

лабораторийн шинжилгээний хариунд үндэслэн баталгаажуулна. Шаардлагатай тохиолдолд олон улсын итгэмжлэгдсэн лабораторид дээж илгээж баталгаажуулна.

- 9.4. Тохиолдлыг тодорхойлж дүн шинжилгээ хийх: ХБХ-ын тохиолдлын шалтгаан, хугацаа, хамрах хүрээ, байрлал, тохиолдлын тоо, хордлогын шинж байдал, нас барагтын тоо, гэмтсэн бэртсэн тохиолдлын тоо, өртсөн хүн ам, өртөөгүй хүн амын тоо, байрлал зэргийг тодорхойлно. Бүлэг хооронд харьцуулсан судалгаа хийнэ. Үүнд: Бүртгэгдсэн тохиолдлуудыг өвчтөний нас, хүйс, оршин суугаа хаяг зэрэг хүчин зүйлсээр жагсаан тоолоод гарсан тоог тухайн газар нутагт амьдардаг нийт хүний тоонд хуваана. Энэхүү тохиолдлын түвшинг бусад бүлгүүдтэй харьцуулна.
- 9.5. Зөвлөмж гаргах: Таамаглалыг баталсаны дараа ард иргэд болон шийдвэр гаргагчдад зориулсан зөвлөмж боловсруулж, үүссэн нөхцөл байдлыг засч, запруулах арга хэмжээ авах удирдамж боловсруулна.
10. Мэргэжлийн баг ХБХ-ын тухай яаралтай тайланг (тархвар судлалын урьдчилсан дүгнэлт) 72 цагийн дотор Эрүүл мэндийн яаманд, эцсийн тайланг (хордлогын дүгнэлт, зөвлөмжийг) 15 хоногийн дотор Эрүүл мэндийн яам болон бусад холбогдох байгууллагад электрон шуудан болон факсаар ирүүлнэ.

66

Эрүүл мэндийн сайдын  
2013 оны 12 сарын 10-ний өдрийн  
**467** тоот тушаалын хоёрдугаар хавсралт

**ХИМИЙН БОДИСЫН ХОРДЛОГЫГ МЭДЭЭЛЭХ МАЯГТ №1**

Д.Д	Хордлогын тохиолдлын огноо	Хордлого анх илэрсэн газар нутгийн нэр	Өртсөн хүний		Хордлогын шалтгаан	Онош	Оношийг лабораториар баталгаажуулсан эсэх	Өвчтөний тавилан
			нас	хүйс				

Мэдээг нэгтгэсэн: ..... овог ..... нэр

..... албан тушаал

..... холбоо барих утас

**ХИМИЙН БОДИСЫН ХОРДЛОГЫГ УЛСЫН ХЭМЖЭЭНД НЭГТГЭН  
МЭДЭЭЛЭХ МАЯГТ №2**

Д.Д	Нийслэл, аймгийн нэр	Илэрсэн хордлогын тохиолдлын тоо	Хордлогын шалтгаан	Хордлогын улмаас нас барсан хүний тоо	Хордлогын зэрэг	Тайлбар


Мэдээг нэгтгэсэн: ..... овог ..... нэр

..... албан тушаал

..... холбоо барих утас

Эрүүл мэндийн сайдын  
2013 оны 12 сарын 10-ний өдрийн  
467 тоот тушаалын гуравдугаар хавсралт А

### Байнгын тандалтын мэдээллийн сүлжээ



—→ Химийн бодисын хордлогын эргэн мэдээлэл

Химийн бодистой холбоотой мэдээлэл

—→ Химийн бодисын хордлогын өвчлөлийн мэдээлэл

Эрүүл мэндийн сайдын  
2013 оны 12 сарын 10.-ний өдрийн  
467 тоот тушаалын гуравдугаар хавсралт Б

Тохиолдол дэгдэлтийн үеийн мэдээллийн сүлжээ

